

ОРОН НУТГИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНД
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН ӨГСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВРЫГ
ЦАГААНДЭЛГЭР СУМАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2019.12.09

№	Өгсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
1	Үйл ажиллагааны хөтөлбөрийн удаашралтай байгаа зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх нэмэлт арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, явцын талаар мэдээлж байх	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн сумдад хамааралтай 52 заалтыг хяналтандаа авч ажиллаж хагас жилийн байдлаар 73,2%-ийн хэрэгжилттэй байлаа. Удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр сумын Засаг даргын зөвлөлийн 2019.06.27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн удаашралтай байгаа 11 заалт бүхий арга хэмжээг хариуцан ажиллах албан тушаалтнуудад тус бүрт нь ажил сайжруулах талаар үүрэг чиглэл өгч ажилласны үр дүнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр жилийн эцсийн байдлаар 90,2 хувьтай хэрэгжсэн байна.	100
2	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх арга хэмжээ, төсөл, хөтөлбөрүүдийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх	- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг ил тод шуурхай зарлах - Төсөл арга хэмжээ бүрийн ажлын гүйцэтгэлд ажлын үе шатны хяналт тавьж, шуурхай зохион байгуулан дуусгах	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 115,945,300 төгрөгний 12 бараа, ажил, үйлчилгээг тусган хуулийн дагуу сумын Засаг даргаар батлуулан байгууллагын мэдээллийн самбар болон шилэн данс, tender.gov.mn, аймгийн цахим хуудсанд байршуулж мэдээллийн цагаар 2 удаа иргэд, албан хаагчдад мэдээлэл хийсэн.	100
3	Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгаж, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, ач холбогдолгүй арга хэмжээнд хөрөнгө зарцуулахыг зогсоох	-Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах, өр авлагагүй ажиллах -Орон нутгийн хөгжлийн санг хууль, журмын дагуу зарцуулж, хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг чанартай гүйцэтгэх, хариуцлагыг дээшлүүлэх	Сар бүр орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилтийн хуваарийг батлагдсан төсвийн хуваарь, маягтийн дагуу хөтөлж зарцуулалтын эрхийг байгууллага тус бүрээр нээж зориулалтын дагуу төсвийн эрх захирагчдын тушаал шийдвэрийн дагуу захиран зарцуулсан. 2019 оны 11-р сард бүх төсөвт байгууллагууд хэмнэлттэй зардлуудаас төсөв хооронд зохицуулалт хийлгэж 2019 оны жилийн эцэст өр авлага үүсгэхгүй ажиллахаар төлөвлөсөн. 2019 онд шинээр нэмэгдсэн өр, авлага байхгүй. 6-р сард Сум хөгжүүлэх сангаас 137,000,000 төгрөгний зээл олгосон, төлөгдөх хугацаа болоогүй. Зээлдэгч нар сар бүр зээлийн хүүгээ тогтмол төлж байна. 2018 оны өр авлагын насжилсан судалгааг гаргасан. Нийт 106,713,952 төгрөгний авлагаас СХСангийн зээл, зээлийн хүүгийн авлага 63,952,350 төгрөг буюу нийт авлагын 59,9%-ийг эзэлж өмнөх оны СХС-ийн авлагаас 90	100

			хувиар буурсан байна. Нийт авлагын 11,179,806 төгрөг буюу 10,4%-ийг найдваргүй авлага, 29,7 хувийг бусад авлага эзэлж байна. Үүнтэй уяалдуулан 2019 оны жилийн эхнээс ажлийн төлөвлөгөө гарган авлага барагдуулах ажил зохион байгуулсан. Сум хөгжүүлэх сангийн 10,100,000 төгрөгний хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулсан. НДШ-ийн 113,478 төгрөгийн өглөгийг барагдуулсан. ОНХСангийн 24,424,300 төгрөгний авлагыг барагдуулсан. Мал хамгаалах сан 2018 оны жилийн эцэст 9,370,500 төгрөгний авлагатай гарсан үүнийг 11 сарын 25-аас эхлэн өвс, тэжээл зээлээр авсан иргэдэд хугацаатай албан мэдэгдэл тарааж авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж байна. Мөн 20,943,600 төгрөгний өглөгтэйгээр 2018 оны тайлангаар гарч байсан бол 11-р сарын байдлаар 12,335,400 төгрөгний өглөгийг барагдуулсан.	
4	Төрийн бодлого, ажлын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулан, нийгмийн баталгааг нь хангах, сургаж чадавхижуулах, шатлан дээшлүүлэх зарчим баримтлах	-Төрийн албаны тухай хуулийг чанд мөрдөн хэрэгжүүлэх талаар сумын ЗДТГ болон харъяа төсвийн байгууллагуудын удирдлагуудыг хариуцлагажуулах -Төрийн албан хаагчдыг сургах, дадлагажуулах, ажлын эцсийн үр дүнд чиглэсэн урамшуулал хариуцлагын тогтолцоо бий болгох	Шинэчлэн батлагдаад хэрэгжиж буй төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журмуудын талаар төрийн албан хаагчид, төсвийн байгууллагын удирдлагуудыг тухай бүр сургалт семинарт хамруулж ажилласан. 2019 оны 1-р сард ЗДТГ-аас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр 12 ажил төлөвлөж албан хаагчдыг ажлын байрны чиг үүргийн дагуу дээд газрын график сургалтуудад хамруулсан. 14 албан хаагчийг давхардсан тоогоор 82 удаагийн сургалт семинарт хамруулсан байна. Мэргэжил олгох болон урт богино хугацааны сургалтанд албан хаагчдад дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Ц.Ундрахбаярыг ХААИС-д суралцаж баклавын боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлж ажилласан. ЗДТГ-ын дарга З.Солонго Удирдлагын академид 7 хоногийн богино хугацааны сургалтанд, МЭТ-ийн дарга Т.Өлзийбат УБ хотод мал эмнэлгийн итгэмжлэл олгох 7 хоногийн сургалт, АБХЭ Г.Эрдэнэтуяа Улаанбаатар хотод Архивын ерөнхий газарт Төрийн архивын баримтанд иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийх арга зүйн чиглэлээр сургалтанд хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байна.	100

			Цэцэрлэгээс 2019 онд үндэсний хэмжээний 2 удаа, орон нутагт зохион байгуулсан 9 удаа, ажлын байрны 6 удаагийн сургалтад эрхлэгч, бүлгийн багш, туслах багш, нярав, тогооч, жижүүр нар хамрагдаж, нийт албан хаагчдын 63% үндэсний болон орон нутгийн сургалтад, 80% ажлын байрны сургалтад хамрагдснаар мэргэжил мэдлэгээ дээшлүүлсэн байна. Туслах багш Б.Өлзийжаргал Улаанбаатар хотод МУБИС-СӨБС-д эчнээгээр суралцаж байна. ЭМТ-өөс эмч ажилчдыг 15 удаагийн сургалтанд хамруулж, 5 эмч, тусгай мэргэжилтний лицензийг сунгуулсан. Бүх эмч ажилчдын жилд цуглуулах кредитийг бүрэн цуглуулсан. Энэ хичээлийн жилд ЕБС-ийн нийт багш ажилчид давхардсан тоогоор ажлын байран дахь 11 сургалтанд 177 хүн, аймаг, үндэсний хэмжээний 14 сургалтанд 22 хүн хамрагдаж мэргэжил боловсролоо дээшлүүлсэн байна.	
5	Байгууллага, орон нутагтаа хууль, журам нэн тэргүүнд хэрэгждэг байх соёл тогтоож, өөрсдөө сахилга хариуцлагатай байж бусдыгаа манлайлах	-Орон нутгийн бүх түвшинд хуулийн хэрэгжилтийг хангах асуудлыг удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид манлайлан ажиллах ёс зүйг тогтоох -Удирдах албан тушаалтнуудыг захиргааны зөрчил гаргах, элдэв гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах -Удирдах албан тушаалтан болон төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын зөрчлийн талаар иргэдээс өргөдөл, гомдлыг авдаг нээлттэй систем тогтоож мөрдүүлэх	Удирдах албан тушаалтнуудыг захиргааны зөрчил гаргах, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж өөрт холбогдох хууль тогтоомжийг байнга судалж байх талаар зөвлөгөө өгсөн. Мөн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар мэдээлэл хийсэн. ТАЗ-ийн 2019 оны 33-р тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн талаар нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Албан хаагчидтай ёс зүй хариуцлагын гэрээ байгуулж ажилладаг. ЗДТГ-т иргэдээс санал, өргөдөл, гомдол хүлээн авах 88601360 нээлттэй утсыг байршуулж иргэдэд сурталчилж ажилласан. 2019 оны 11 сарын 09-10-нд Баянжаргалан суманд зүүн бүсийн сумдын ЗДТГ-ын албан хаагчдыг хамруулсан зөвлөгөөнийг сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж албан хаагчдыг 100% оролцуулан ТА-ын шинэтгэл, ТАХ-ын ёс зүй хариуцлагын тухай сургалтанд хамруулсан.	100

			 	
6	“Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Авилгатай тэмцэх газрын хүргүүлсэн зөвлөмжийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, хэрэгжилтийг тайлагнах (хууль бус төлбөр хураамж бий эсэх, түүний зарцуулалтын байдал, худалдах авах ажиллагааг хууль, бусаар явуулснаас, төрийн албан хаагчдыг хууль бусаар ажилаас нь чөлөөлсний улмаас төсөвт хохирол учруулсан байдал, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад хийсэн шалгалтын тухай, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц хөрөнгө гэх төсвийн зүйл анги бий болгосон эсэх, түүний зарцуулалтын талаар)	Авилгатай тэмцэх газраас 2019.01.07-ны өдрийн 01/475 албан бичгээр ирсэн зөвлөмжийн дагуу суманд хэрэгжүүлэх ажлын 8 заалт бүхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг гаргаж ажилласан байна. Мөн Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хяналтандаа аван ажилласан. Авлигагүй Цагаандэлгэр уриалгыг өрнүүлж төрийн байгууллагын дарга эрхлэгч, төрийн захиргааны албан хаагчдыг үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод нээлттэй байдлыг эрхэмлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хүнд сурталгүй сум, албан хаагч болцгооё уриалгад нэгдсэн ба авлига авахгүй өгөхгүй энгэрийн тэмдгийн ажлын байрандаа зүүж хэвшсэн байна. 2019 онд ЭМТ-ийн даргаар томилогдох А.Өлзийжаргал, сургалтын менежер О.Ариунаа нарын нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлэн хянуулсан ба томилогдсоноос хойш 30 хоногт багтаан ХАСХОМ-ыг гаргуулж цахимд бүртгэн баталгааны маягтаар баталгаажуулсан. Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай 1, зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн 10 мэдэгдэл тайлбарыг хүлээн авч бүртгэсэн.	100

			Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Хууль тогтоомж сурталчлах өдөрлөгийг 12 сарын 06-нд 60 гаруй иргэд ТАХ-дад АТГ-аас 2019 оны өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, эрүүгийн хуулинд заасан авлигын гэмт хэргийн талаарх ойлголт мэдээллийг хүргэсэн. Мөн ХАСХОМ гаргагч 13 албан тушаалтанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ХАСХОМ хэрхэн мэдүүлэх, мэдэгдэл тайлбарыг хэрхэн гаргах талаар сургалт зохион байгуулсан. 12 сарын 9 буюу Авлигын эсрэг дэлхийн өдрийг угтан ЕБС-ийн сурагчид болон иргэдийн дунд зохион байгуулсан Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” эссэ бичлэгийн уралдаан 5 эссэ ирүүлж 1-р байрыг МУИС-ын 2-р курсын оюутан Э.Гантуяа, 2-р байрыг ГСА-ийн 2-р сургуулийн 11а ангийн сурагч О.Сэр-Од, 3-р байрг ЕБС-ийн 9а ангийн сурагч Д.Шинэбаяр нар тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. “Шударга ёс ямар өнгөтэй вэ” гар зургийн уралдаанд 10 бүтээл ирүүлснээс 1-р байранд 8а ангийн сурагч Б.Батзориг, 2-р байранд 9а ангийн сурагч Б.Сэржхандам, 3-р байранд 8а ангийн сурагч Э.Эрдэнэтөгс, тусгай байранд 8а ангийн сурагч М.Хурхарцага нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.	
--	--	--	---	--

				
7	Төрийн үйлчилгээг иргэддээ ойртуулах чиглэлээр идэвх, санаачлагатай ажиллах. Иргэдэд учирч байгаа бэрхшээлтэй асуудал, хэрэгцээ шаардлагыг нь мэдэрч, төрийн бодлого, шийдвэрт тусгах, түүнд нийцүүлэх, ил тод, нээлттэй засаглалыг төлөвшүүлэх	-Иргэдэд үзүүлдэг үйлчилгээ цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг өгөх -Иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа аливаа асуудлаар гомдол, саналыг шуурхай авч шийдвэрлэх жижүүрийн албыг ажиллуулах	Нийгмийн даатгалаас ухаалаг гар утас ашиглан өөрийн тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэнд, сайн дурын даатгал төлөлтийн талаарх мэдээллийг бүрэн авах боломжтой болсон. Мөн интернэт банкныг ашиглаж эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгалын шимтгэлээ гэрээсээ төлөх боломж бүрдсэн талаарх мэдээллүүдийг иргэдэд хүргэж ажилласан байна. E-tax.mn, mta.mn-ний өөрчлөлт TAIS программын нэвтрүүлснээр иргэдэд хүргэх үйлчилгээ цахимд бүрэн шилжиж нэхэмжлэх, төлбөрийн даалгаврын дагуу банкны Qrau, интернэт, экспресс банк ашиглан татварыг төлдөг болсон. Мөн burtgel.mn сайтыг ашиглан иргэний үнэмлэх захиалах, иргэний бүртгэлийн 15 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн 5 лавлагаа, хуулийн этгээдийн 2 лавлагааг цахимаар авах боломж бүрдсэн. Сумын хэмжээнд 2019 оны байдлаар 301 өргөдөл ирснээс 281 өргөдлийг хуулийн хугацаанд нь шуурхай шийдвэрлэж 93,3%-тай байна. Байгууллага бүрээр авч үзвэл ЗДТГ-т нийт 173 СӨГ ирсэн байна. Үүнээс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж	100

			үйлчилгээтэй холбоотой 124, ХАА-тай холбоотой 11, ажлаас чөлөөлөгдөх 3, ажилд орох өргөдөл 4, бэлчээр нутгийн маргаантай 10, мал эмнэлгийн үйлчилгээний холбоотой 6, чөлөө хүссэн 15 өргөдөл байна. ЕБС-д 15 СӨГомдол ирсэн. ӨГСХ-ийг захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэдэг. Энэ хичээлийн жилд ажлаас чөлөөлөгдөх өргөдөл 4, ажилд орох өргөдөл 3, чөлөө хүссэн 8 ирснийг цаг тухай бүрт нь хуралдан шийдвэрлэж зохих арга хэмжээнүүдийг авсан. Цэцэрлэгт 18 санал, хүсэлт, ажилд орохыг хүссэн өргөдөл 16, ажлаас гаргах өргөдөл 2 ирснийг цаг тухай бүрт нь шийдвэрлэж зохих арга хэмжээнүүдийг авч ажилласан. ЗДТГ-т иргэдээс санал, өргөдөл, гомдол хүлээн авах 88601360 нээлттэй утсыг байршуулж иргэдэд сурталчилж ажилласан. Иргэдээс ТАХ-ийн үйл ажиллагаатай холбоотой хүнд суртал, чирэгдэл үүсгэсэн аливаа асуудлаар гомдол, саналыг гараагүй.	
		Төрийн байгууллагын бүх шатны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан бүр хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлж, хууль тогтоомж болон хариуцсан үйл ажиллагаагаа сурталчилах, тайлагнах, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хэрэглэгч, үйлчлүүлэгчийг тасралтгүй хангах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх замаар хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн баталгааг хангах	 Төрийн байгууллагууд болон төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл, шинэчлэгдсэн хууль тогтоомж, мэдээ мэдээллээр иргэдэд цахим хэрэгсэл болон мэдээллийн цагаар тогтмол хүргэж ажиллаж байна. Иргэд рүү чиглэсэн тэдний оролцоо идэвхийг нэмэгдүүлэхэд анхаарч 2019 оны 5 сард “Хүлээж биш хүрч үйлчилье” төрийн үйлчилгээний өдөрлөгийг 4 багийн төв дээр зохион байгуулж ЗДТГ болон бусад төрийн байгууллагуудын өргөн бүрэлдэхүүнтэй ажиллаж төрийн үйлчилгээг хүргэж, зөвлөгөө мэдээлэл өгч 250 гаруй иргэдийг хамруулсан.	100
8	Малын зүй бус хорогдлоос урьдчилан сэргийлж, мал төллөлтөд хариуцлагатай хандах	Мал төллөлт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангаж, хохирол багатай даван туулах чиглэлээр хийсэн ажлын тайлан ирүүлэх	Сумын Засаг даргын захирамжаар хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах 2 ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө гаргаж ажилласан. Сумын өвсний фондод 9,2 тн тэжээл, 20 тн өвс бэлтгэсэн байна. Мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг 7 хоногийн 3 дахь өдөр бүр мэдээлж ирсэн байна. Сумын дүнгээр 63122 хээлтэгч мал төллөхөөс 56295 хээлтэгч төллөж 122 төл хоргдсон байна. Одоо 56173 төл бойжиж, төл бойжилт 98,9	100

			хувьтай байна. Мал төллөлт 89 хувьтай байна. Гүү, үнээ төллөлт оройтож сүүлийн мэдээнд ороогүй байна.	
9	Байгаль орчны нөхөн сэргээлт, бэлчээрийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарах. Шаардлагатай бол дээд шатны байгууллагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авч байх	-Нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийгээгүй газрын судалгааг гарган хуулийн байгууллагад хандах шийдвэрлүүлэх -Байгаль орчны нөхөн сэргээлт, бэлчээрийн даац, онцлог байдлын талаар судалгаа хийж, зохист байдлыг ханган нүүдэллэх, оторлох зэрэг байдлаар зохицуулалт хийх	4 багийн нутаг дэвсгэрт үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх ажлыг багийн дарга нартай хамтран зохион байгуулж 71 малчин оролцон 2,1 сая төгрөгийн зардал гарган ажиллалаа. 1-р багийн нутагт байрлах Өндөр сүүж гэдэг газарт олон жил хайгуулын үйл ажиллагааг хийж байсан Сүмбэр орд ХХКомпаниар хайгуулын үйл ажиллагааг дуусмагц байгаль орчны нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийлгэж хүлээн авах ажлыг зохион байгуулсан.	100
10	Төрийн албан хаагчдын хариуцлага, санаачилгагүй байдлаас болж гарах гэнэтийн аюул, ослыг эрс бууруулах хүний амь нас, тэр дундаа хүүхдүүдийн амь нас үрэгдэх явдлыг таслан зогсоох чиглэлээр шийдвэртэй арга хэмжээ авч байх	-Гэнэтийн аюул осол гардаг асуудлуудын судалгааг гарган шалтгааныг арилгах арга хэмжээ шуурхай авч хэрэгжүүлэх -Гэнэтийн аюул, осол гарах, амь нас, тэр дундаа хүүхдүүдийн амь нас үрэгдэх эрсдлийн талаар иргэдийн саналыг авч, шийдвэрлэх мэдээллийн үйлчилгээг сум, дүүрэг, аймаг, нийслэлд бий болгон тогтмол ажиллуулах	Төрийн байгууллагуудын албан хаагчдын хариуцлагагүй, санаачлагагүй байдлаас ажлын байранд гарч болох аливаа эрсдлийг гаргахгүйн тулд албан хаагчдад албан өрөөнийхөө тог цахилгааныг байнга шалгаж ажлаас гарч байх, компьютер техник хэрэгслийг тог цахилгаанаас салгаж байх, 24 цагаар гар утсаа байнга нээлттэй байх талаар байгууллагын дотоод журамд заалт оруулж тогтмол анхаарч мөрдөж ажиллах байхыг анхааруулж байна. Гэнэтийн аюул осол гарах, хүүхдийн амь нас үрэгдэх эрсдлийн талаар иргэдэд мэдээлж тэдний санал бодлыг сонссон. Үүнд насанд хүрээгүй хүүхдүүд тээврийн хэрэгсэл унан замын хөдөлгөөнд оролцож байгаа асуудал хамгийн их анхаарал татаад байна. Энэ зөрчлийг таслан зогсоохын тулд сумын ГХУССЗ-ийн гишүүд өрхийн тэргүүлэгч нартай гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөсөн. Хүүхэд хамгаалах хамтарсан багийн гишүүд уул овооны тахилга наадам болон сумын баяр наадмаар унаач хүүхдүүдийн аюулгүй байдалд анхаарч ажилласан. Уяачидтай гэрээг байгуулан унаач хүүхдүүдийн хувцас хэрэглэлд болон хүүхдийн амь нас, эрүүл мэндэд анхаарахыг зөвлөж ажилласан.	100
11	Хөдөө аж ахуй салбарын дэвшилтэт техник, технологи инноваци нэвтрүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллах	Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажил, импортын хүнсний бүтээгдэхүүнээс татгалзаж хүнсний хэрэглээг нутгийн эко бүтээгдэхүүнээр хангах, эх оронч худалдан авалтыг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулж тайланг ирүүлэх	2019 онд суманд 6 иргэн 1 албан байгууллага, эмэгтэйчүүдийн 1 бүлэг 05 га-д төмс, хүнсний ногоо тариалан төмс 400 кг төмс, огурци 400 кг сонгино, 80 кг хураан авч сумын иргэдэд эко бүтээгдэхүүнээр үйлчилж худалдан борлуулсан байна. Дулаан бэлэг хоршоо цагаан эсгий үйлдвэрлэж иргэдэд худалдан борлуулж байна.	70

12	Орон нутгийн өрсөлдөх чадварыг сайжруулах	-Сайн засаглал болон бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр санаачлагыг дэмжих	2019 онд сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдахаар 5 ААН, 9 иргэн төсөл бичиж ирүүлсэн. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл 2019 оны 02 сарын 19-ны өдрийн хуралдаанаар тус төслүүдийг хэлэлцэн Цаст-Ундрага ХХК-ны “Чацаргана “ 20,0 сая төгрөгийн “Мал эмнэлэгийн үйлчилгээ чанар хүртээмжийг сайжруулах” 25,0 сая төгрөгийн төслийг хугацаа хоцроож ирснээс хэлэлцэхгүй гэсэн шийдвэр гаргасан. Мөн Т.Түмэннастын “Модон эдлэл” 9991000 төгрөгийн төслийг ЖДҮ сангаас зээл авч үйл ажиллагаа явуулж байгаа учраас зээл олгох боломжгүй гэж үзэн хэлэлцээгүй. 8 иргэн, 1 Хоршоо, 2 ААН-д 137 сая төгрөгийн зээл олголоо. Одоогоор сум хөгжүүлэх санд 19 иргэн, 3 ААН зээлийн үлдэгдэлтэй ажиллаж байна.	70
13	Түүх соёлын өвийг хадгалах, хамгаалах	“Соёлын биет бус өв”, “Чулуун соёлын өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөрийг сурталчилж, хүүхэд, залуучуудад түүх, соёлын өвийг хадгалах, хамгаалах чиглэлээр хийх ажил, арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллах	Соёлын биет бус өвийн 1 дэх ай сав: Монгол ардын эх хэл, аман уламжлал, илэрхийлэлүүдийн төрөл зүйл ангилал ай савд нийт 4 өвлөн уламжлалч СББӨвийн 2 дах ай сав: Монгол ардын язгуур урлаг ай савд нийт 10 өвлөн уламжлагч СББӨвийн 3 дах ай сав: Уламжлалт зан үйл, ёслол баяр наадам ай савд 12 өвлөн уламжлагч СББӨвийн 4 дэх ай сав: Байгалийн болон сав ертөнц шинжих ай савд 8 өвлөн уламжлагч СББӨвийн 5 дах ай сав: Ардын уламжлалт гар урлал ай савд 8 өвлөн уламжлагч бүртгэлтэй байна. 2019 онд шинээр 19 өвлөн уламжлагчийг бүртгэн авч бүртгэл мэдээллийн санг баяжууллаа. Цагаандэлгэр сум нь Боржигины голомт нутаг бөгөөд “Боржигин найр”-ын дэг ёсыг авч үлдсэн цөөхөн сумдын нэг юм. Найрын дэг жаягийг нутгийн ард иргэд болон зэргэлдээх аймаг, сумдын иргэд, хүүхэд залуучуудад сурталчилан таниулах зорилгоор жил бүр “Боржигин найр”-ын үзүүлэх тоглолтыг хийж хэвшсэн. Энэ онд Говьсүмбэр аймгийн Баянтал суманд зохион байгуулагдсан “Боржигин - 2019” соёлын биет бус өвийн их наадамд боржигины 5 аймгийн 13 сумаас Тэргүүн байранд шалгарсан юм.	100



“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийн хүрээнд: ТСҮХДурсгалт 29 газраас аймгийн хамгаалалтанд 1, 28 газар сум болон байгууллагын хамгаалалтанд байна. Үүнээс 12 газрыг ойролцоох нутагладаг 12 малчидтай гэрээ хийж хамгаалалтанд авсан. Мөн 4-р багийн иргэн Т.Түмэннастын санал санаачлага, хандив тусламжаар ТСҮХДГазар болох **“Хөшөөтийн тахилын онгон”** хэмээх 2 хөшөө чулууг босгож, 9м2 төмөр хашааг босгож хамгаалалтыг сайжруулсан бол, 4-р багийн иргэн Н.Дэлгэрбилэгийн гэр бүлтэй хамтран ТСҮХДГазар болох Цагаан айргийн **“Хүн чулуу хөшөө”** – нд 16м2 модон хашааг босгож хамгаалалтыг сайжруулсан. ОНСТанхимаас сумын хэмжээн дэх чулуун дээрх сийлбэр /зураг, бичвэр/-ийн судалгааг авч нийт 3 дурсгалт газар бүртгэгдээд байгаа бол чулуун цуглуулгатай иргэдийн судалгааг авч нийт 5 иргэн бүртгэгдлээ. Мөн сурагчдын дунд “Чулуун наадгай” уралдааныг зохион байгуулж нийт 11 бүтээл оролцсон. Соёлын төвийн ОНСТанхимд түүхэн дурсгалт 2 газрын чулууны дээжийг авч хадгалж байна. Мөн соёлын төвөөс “Чулуу таалцах” уламжлалт тоглоомыг үйлдвэрлэж, ард иргэдэд сурталчилж байна.



			 	
14	Бодлого, шийдвэр, хууль тогтоомж, тэдгээрт заагдсан иргэдийн эрх, үүрэг, оролцоог шинэлэг арга хэлбэрээр сурталчилж байх, иргэдээ соён гэгээрүүлэх	-Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, төр, засгийн бодлого, шийдвэрийг сурталчилах чиглэлээр төлөвлөгөө гаргах ажиллах -Засаг захиргааны бүх шатны нэгж, төрийн байгууллагууд, иргэдийн дунд соён гэгээрүүлэх, хүмүүжлийн ажлыг өрнүүлэх	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Мөн энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗДТГ-ын даргаар ахлуулсан “Эрх зүйн хөтөч” багийг шинэчлэн томилсон. Сумын эрх зүйн хөтөч багаас 2019 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 70 хууль тогтоомжийг судлуулахаар төлөвлөсөн. Үүнээс 11 сарын эцсийн байдлаар 35 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 497, төлөвлөгөөнөөс гадна 5 удаагийн мэдээлэл сургалтанд давхардсан тоогоор 116 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан. Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтанд 4 албан хаагчийг хамруулсан байна. Эрх зүйн хөтөч багаас Эрх зүйн мэдлэгийг иргэн бүрт” эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж нийт 191 өрхийн 264 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл, тусалцаа үзүүлсэн байна. 11 сарын 13-нд аймгийн ЗД, АЗДТГ-аас “Иргэдээ сонсоё” төрийн үйлчилгээний өдөрлөгийг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж аймгаас очиж авдаг төрийн үйлчилгээг сумаас авах нөхцөл боломжийг бүрдүүлж 50 орчим төрийн албан хаагчид ирж ажиллаж 120 гаруй иргэд хамрагдсан байна. ЗДТГ-аар үйлчлүүлж буй иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө, шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомж, бусад мэдээллийг хүргэх зорилгоор видео хичээл, шторкыг тогтмол явуулж байх нөхцлийг бүрдүүлж үүдний хэсгийг иргэдэд ээлтэй байдлаар тохижуулаад байна. 	100
15	Багийн Засаг дарга, байгууллагын дарга нарын	Засаг захиргааны нэгж, байгууллагын удирдлагын ажлыг үнэлж дүгнэхэд	Багийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр ажлыг дүгнэсэн.	100

	үйл ажиллагааг дүгнэх чиглэлээр шинэчлэл хийх	ажилгүйдэл, ядуурлын түншинг бууруулах чиглэлээр гаргасан санаачилга, хийсэн ажил, түүний хэрэгжилтийн байдлыг харгалздаг үнэлгээг бий болгох	Байгууллагын дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг хага, бүтэн жилээр дүгнэсэн.	
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ				96.25

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

З.СОЛОНГО